

2025 ОНЫ 08 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-08-11

Өндөртөлгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 08 дугаар сарын 20-ны “Лхагва” гарагийн 11:00 цагаас өмнө** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.
8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;
8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;
8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;
8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилогдсоноос хойшхи хугацаанд хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хийсэн ажлын хэрэгжилт, үр дүнг нэгтгэн танилцуулах.	ЗДТГ-Бодлогын хэлтсүүд
2	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, хяналт тавих.	ЗДТГ-ТЗУХ Нийт байгууллагууд
3	Төрийн захиргааны албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах ажлын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, орон тооны өөрчлөлтийн талаар санал боловсруулж танилцуулах.	ЗДТГ-ТЗУХ
4	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд инженер хангамжийн ажлуудыг эрчимжүүлж, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах.	ТХҮХ
5	Төсвийн орлогын төлөвлөгөөг бүрдүүлэх ажлаа эрчимжүүлэх, төсвийн орлогыг жигд ханган биелүүлэх, нэр төрөл бүрээр биелэлтийг хангуулах чиглэлээр ажил зохион байгуулах.	СТСХ, Татварын хэлтэс
6	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангуулах, хяналтын камерын ажиллагааг шалгаж, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх.	НХХ, БХ, ЕБС, СӨББ-ууд, Цагдаагийн хэлтэс, “Багахангайн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ
7	Хүнсний худалдааны төвүүдэд хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулах.	ТХҮХ, Б.Намуунтуяа (НХХААГ-ын Хяналтын хэлтсийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)
8	Авто зам, явган замуудын нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, стандарт шаардлагыг хангуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Ажлын хэсэг
9	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хийж хэрэгжүүлж байгаа ажлаа иргэд, олон нийтэд сурталчлах.	Нийт байгууллагууд
10	Нохой, муур устгах ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Хороод
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
11	Дүүргийн хэмжээнд байгаа худгуудыг лайдах, худгийн тагны битүүмжийг сайжруулах ажлыг 08 дугаар сарын 20-ны дотор гүйцэтгэж дуусгах.	Инженер хангамжийн байгууллагууд
12	Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг эрчимжүүлэх.	ХААА, холбогдох ашиглагч байгууллагууд
13	Хот нийтийн аж ахуйн чиглэлийн машин механизмын ашиглалт, үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэн иргэд, олон	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ

	нийтэд танилцуулах, машин механизм, тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөрийг барагдуулахтай холбогдуулан дээрх машин механизмуудын үнийн мэдээллийг нэгтгэн албан бичгээр холбогдох газарт хүргүүлэх.	
14	Нийтийн эзэмшлийн болон, ААНБ, айл өрхийн орчны ногоон байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах.	ТХҮХ, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, нийт байгууллага
15	2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хороодын Засаг дарга нартай уулзах уулзалтын бэлтгэлийг сайтар ханган холбогдох ажлуудын гүйцэтгэлийг эрчимжүүлэх.	ЗДТГ, Хороод
16	Дүүргийн төсөвт тодотгол хийгдэхтэй холбогдуулан холбогдох материалыг бэлтгэн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд хугацаанд нь хүргүүлэх.	СТСХ
17	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан сурагчдыг шинжилгээнд бүрэн хамруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах.	НХХ, БХ, ЕБС, СӨББ-ууд, ЭМТ

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ГАДААД ХАРИЛЦАА ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ГЭРЭЛЦОЛМОН

НЭГТГЭСЭН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР